| 1 | Далайн хоолойн 200 метр урт гүүрийн барилга, зураг төсөв, Хөвсгөл | 2006-2008 | 1618.0 | 200.0 |
| 2 | Нарийны голын гүүрийн барилга, зураг төсөл, Увс,Тэс сум | 2006-2008 | 2100.0 | 600.0 |
| | Шилжих | | 1087.4 | 427.4 |
| 1 | Буянтын голын 180.5 метр урт төмөр бетон гүүр, Завхан | 2002-2006 | 667.4 | 107.4 |
| 2 | Тээлийн голын 75 метр урт гүүр, Увс, Улаангом | 2005-2006 | 420.0 | 320.0 |
| IY | **"Мянганы зам" төсөл** | | **15295.0** | **2030.0** |
| IY.1 | **Хатуу хучилттай зам** | | **14915.0** | **1950.0** |
| | Шилжих | | 14915.0 | 1950.0 |
| 1 | Багануур-Өндөрхааны Устын Уул-Дуутын даваа чиглэлийн 100 км хатуу хучилттай зам | 2004-2007 | 13715.0 | 1150.0 |
| 2 | Баяннуур-Дашинчилэнгийн 6.5 км хатуу хучилттай зам | 2005-2007 | 1200.0 | 800.0 |
| IY.2 | **Гүүр** | | **380.0** | **80.0** |
| | Шилжих | | 380.0 | 80.0 |
| 1 | Цэнхэрийн голын 60 метр урт гүүр, Хэнтий | 2005-2006 | 380.0 | 80.0 |
| Y | **Эргэн төлөгдөх нөхцөлөөр баригдах зам, гүүр** | | **162211.2** | |

| | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүч чадал | Хэрэгжүүлэх хугацаа | Төсөвт өртөг | Үүнээс: 2006 онд санхүүжих |
|---|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар-Эрдэнэсантын 176 км хатуу хучилттай замын өргөтгөл, шинэчлэлт | 2006-2009 | 34355.2 | |
| 2 | Хархорин-Цэцэрлэгийн 115 км хайрган замын өргөтгөл | 2007-2010 | 11224.0 | |
| 3 | Цэцэрлэг-Цэцүүх-Тосонцэнгэл-Улаангом чиглэлийн 530 км хатуу хучилттай зам | 2006-2015 | 77592.0 | |
| 4 | Өндөрхаан-Дорнод-Сүмбэр чиглэлийн 200 км хатуу хучилттай зам | 2007-2010 | 39040.0 | |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 2 дугаар сарын 15–ны өдөр** **Дугаар 20** **Улаанбаатар хот**

**Ажлаас чөлөөлөх, ажилд түр томилох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өөр ажилд шилжсэн тул Лувсандандарын Хангайг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Жамъянхорлоогийн Сүхбаатарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргаар түр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД М.ЭНХСАЙХАН**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 2 дугаар сарын 15–ны өдөр** **Дугаар 22** **Улаанбаатар хот**

**Босго үнэ батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1, 19.1 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2005 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолоор батлагдсан босго үнийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхий менежерт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайханд тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 101 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД Н.БАЯРТСАЙХАН**

*Засгийн газрын 2006 оны 22 дугаар тогтоолын хавсралт*

## ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ЖУРМЫГ СОНГОХОД БАРИМТЛАХ БОСГО ҮНЭ

| № | Ангилал / Босго үнийн төрөл | Бараа | Ажил | Үйлчилгээ | |
|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөх | бусад |
| 1 | Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар | 30 сая төгрөг | 50 сая төгрөг | 10 сая төгрөг | 30 сая төгрөг |
| 2 | Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар | 1 сая төгрөг | - | 1 сая төгрөг | 1 сая төгрөг |
| 3 | Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох төсөвт өртгийн дээд хязгаар | - | - | 2 сая төгрөг | - |
| 4 | Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл олгох төсөвт өртгийн доод хязгаар | 800 сая төгрөг | 1 тэрбум төгрөг | 200 сая төгрөг | 800 сая төгрөг |
| 5 | ВЭБ хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх төсөвт өртгийн доод хязгаар | 50 сая төгрөг | 100 сая төгрөг | 50 сая төгрөг | 50 сая төгрөг |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 2 дугаар сарын 15–ны өдөр** **Дугаар 23** **Улаанбаатар хот**

**Тогтоолын зарим хавсралтыг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 12.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын төсвийн орлого, зарлагын ангилал батлах тухай" Засгийн газрын 2003 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 203 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг 1 дүгээр, мөн тогтоолын 3 дугаар хавсралтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн дагуу тухайн жилийн төсвийн төсөл болон Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тайланг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бүтээгдэхүүний ерөнхий ангийг баримтлан гаргаж байхыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД Н.БАЯРТСАЙХАН**

*Засгийн газрын 2006 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

## ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЕРӨНХИЙ АНГИ

| | |
|---|---|
| | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга |
| 1 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 2 | Ерөнхийлөгчийн бүрэн эрх, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлэх үйлчилгээ |
| 3 | Сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа |
| 4 | Хяналт, үнэлгээ, шинжилгээний үйл ажиллагаа |
| 5 | Мэдээлэл, лавлагаа, мэдээллийн технологийн үйл ажиллагаа |
| 6 | Бусад үйл ажиллагаа |
| | Монгол Улсын Их Хурлын дарга |
| 1 | Бодлого, төлөвлөлт, мэргэжлийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 2 | УИХ-ын хууль тогтоомжийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагаа |
| 3 | Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа |
| 4 | Бусад үйл ажиллагаа |
| | Монгол Улсын Ерөнхий сайд |
| 1 | Монгол Улсын Ерөнхий сайдын үйл ажиллагаа |
| 2 | Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн зохицуулалтын үйл ажиллагаа |
| 3 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалт, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа |

| | |
|---|---|
| 4 | Төрийн тусгай холбоо, төрийн хамгаалалтын үйл ажиллагаа |
| 5 | Бусад үйл ажиллагаа |
| | Монгол Улсын Шадар сайд |
| 1 | Бүс нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, зохицуулалт, хяналтын үйл ажиллагаа |
| 2 | Хэмжих хэрэгсэл болон чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа |
| 3 | Стандарт, чанар, хэмжил зүйн төрийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа |
| 4 | Оюуны өмчийг хамгаалах төрийн хяналтын үйл ажиллагаа |
| 5 | Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах үйл ажиллагаа |
| 6 | Зах зээлд шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа |
| 7 | Шударга бус өрсөлдөөний төрийн хяналт, шалгалтын үйл ажиллагаа |
| 8 | Хүүхдийн эрхийн байдалд хяналт тавьж, зөрчигдөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа |
| 9 | Хүүхдэд үзүүлэх асрамж үйлчилгээ, амралт, чөлөөт цагийн төвүүдийн үйл ажиллагаа |
| 10 | Бусад үйл ажиллагаа |
| | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга |
| 1 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 2 | Засгийн газрын танхимд үзүүлэх үйл ажиллагаа |
| 3 | Мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа |
| 4 | Хяналт, шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа |
| 5 | Олон нийттэй харилцах үйлчилгээ |
| 6 | Төрийн ёслолын үйл ажиллагаа |
| 7 | Төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах нийтлэг үйлчилгээ |
| 8 | Төрийн албан хаагчдын сургалтын үйл ажиллагаа |
| 9 | Бусад үйл ажиллагаа |
| | Гадаад хэргийн сайд |
| 1 | Монгол Улсын төрийн гадаад бодлого, гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн үйл ажиллагаа |
| 2 | Монгол Улсын консул, визийн үйлчилгээ |
| 3 | Монгол Улсын төрийн гадаад бодлогын мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа |
| 4 | Удирдлагын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагаа |
| 5 | Бусад үйл ажиллагаа |
| | Сангийн сайд |
| 1 | Эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа |
| 2 | Салбарын хөгжил, санхүүгийн зах зээл, хөрөнгө оруулалтын удирдлагын үйл ажиллагаа |
| 3 | Төсвийн удирдлагын үйл ажиллагаа |
| 4 | Засгийн газрын мөнгөн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа |
| 5 | Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлагын үйл ажиллагаа |
| 6 | Зээл, тусламжийн удирдлагын үйл ажиллагаа |
| 7 | Нягтлан бодох бүртгэл, аудитын удирдлагын үйл ажиллагаа |
| 8 | Төрийн захиргааны удирдлагын үйл ажиллагаа |
| 9 | Бусад үйл ажиллагаа |
| | Хууль зүй, дотоод хэргийн сайд |
| 1 | Эрх зүйн бодлого, шинэтгэл, төлөвлөлтийн үйл ажиллагаа |
| 2 | Удирдах дээд болон төрийн байгууллагад хууль зүйн бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 3 | Эрх зүйн албан болон албан бус сургалтын үйлчилгээ |
| 4 | Иргэний бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаа |
| 5 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сурталчлах үйл ажиллагаа |
| 6 | Гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журмыг хамгаалах үйл ажиллагаа |
| 7 | Хил хамгаалалтын үйл ажиллагаа |
| 8 | Цагдан хорих, баривчлах, албадан саатуулах үйл ажиллагаа |
| 9 | Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа |

| | |
|---|---|
| 10 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, ослоос сэргийлэх үйл ажиллагаа |
| 11 | Төрийн тусгай албан хаагчдын сургалт, бэлтгэлийн үйл ажиллагаа |
| 12 | Эрх зүйн эрдэм шинжилгээ, мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа |
| 13 | Тусгай зөвшөөрөл олгох болон улсын бүртгэлийн үйлчилгээ |
| 14 | Гадаадын иргэдийн бүртгэл, оршин суух зөвшөөрлийн үйлчилгээ |
| 15 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйлчилгээ |
| 16 | Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа |
| 17 | Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд үзүүлэх тусламж, үйлчилгээ |
| 18 | Бусад үйл ажиллагаа |
| | Байгаль орчны сайд |
| 1 | Ойжуулалт, ойг нөхөн сэргээх, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаа |
| 2 | Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, усны бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа |
| 3 | Ус, цаг уур, орчны шинжилгээний шуурхай мэдээллээр хангах үйлчилгээ |
| 4 | Байгаль орчны хамгаалал, хяналт шинжилгээний үйл ажиллагаа |
| 5 | Ховор, нэн ховор ан амьтан, ургамлыг хамгаалах, сэргээн нутагшуулах, тарималжуулах үйл ажиллагаа |
| 6 | Дархан цаазат болон тусгай хамгаалалттай газрыг хамгаалах үйл ажиллагаа |
| 7 | Хот, суурин газрын агаар, хөрс, усны бохирдлыг багасгах, хог хаягдлыг боловсруулах үйл ажиллагаа |
| 8 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 9 | Бусад үйл ажиллагаа |
| | Батлан хамгаалахын сайд |
| 1 | Батлан хамгаалахад холбогдох хууль,тогтоомж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагаа |
| 2 | Улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах, тодотгох, сургалт явуулах үйл ажиллагаа |
| 3 | Зэвсэгт хүчний үйл ажиллагаа |
| 4 | Салбарын боловсон хүчний сургалт, бэлтгэл, судалгаа–шинжилгээний ажил, үйлчилгээ |
| 5 | Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа |
| 6 | Салбарын соёл, урлагийн үйлчилгээ |
| 7 | Батлан хамгаалах салбарын эрүүл мэнд, спортын үйл ажиллагаа |
| 8 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 9 | Бусад үйл ажиллагаа |
| | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| 1 | Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ |
| 2 | Бага, дунд боловсролын үйлчилгээ |
| 3 | Мэргэжлийн боловсрол, сургалтын үйлчилгээ |
| 4 | Дээд боловсролын үйлчилгээ |
| 5 | Соёл, урлагийн үйлчилгээ |
| 6 | Шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ |
| 7 | Соёл, урлаг, шинжлэх ухаан, технологийн болон сургалтын төрийн сангийн үйлчилгээ |
| 8 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны орчинг бүрдүүлэх үйл ажиллагаа |
| 9 | Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа |
| 10 | Төрийн захиргааны удирдлага, гадаад хамтын ажиллагааны үйлчилгээ |
| 11 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 12 | Бусад үйл ажиллагаа |
| | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд |
| 1 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 2 | Хүн амын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа |
| 3 | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн удирдлагын үйл ажиллагаа |
| 4 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаа |
| 5 | Нийгмийн даатгалын үйлчилгээ |

| | |
|---|---|
| 6 | Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаа |
| 7 | Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээ |
| 8 | Олон нийтийн байгууллагаар гүйцэтгүүлэх төрийн захиалгат үйлчилгээ |
| 9 | Бусад үйл ажиллагаа |
| | Үйлдвэр, худалдааны сайд |
| 1 | Хөдөө орон нутагт бөөний худалдааны сүлжээг өргөтгөн бэхжүүлэх үйл ажиллагаа |
| 2 | Худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа |
| 3 | Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын үйл ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, сурталчлах үйл ажиллагаа |
| 4 | Ашигт малтмал, газрын тосны үйл ажиллагаа |
| 5 | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх үйл ажиллагаа |
| 6 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 7 | Бусад үйл ажиллагаа |
| | Хүнс, хөдөө аж ахуйн сайд |
| 1 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 2 | Мал аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ |
| 3 | Газар тариалангийн үйлдвэрлэл, үйлчилгээ |
| 4 | Мал эмнэлгийн үйлчилгээ |
| 5 | Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ |
| 6 | Бэлчээрийг хортон мэрэгчээс хамгаалах үйл ажиллагаа |
| 7 | Бэлчээрийн усан хангамжийн үйлчилгээ |
| 8 | Бусад үйл ажиллагаа |
| | Эрүүл мэндийн сайд |
| 1 | Урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ |
| 2 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ |
| 3 | Нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ |
| 4 | Удаан хугацааны асаргаа сувилгааны үйлчилгээ |
| 5 | Эрүүл мэндийн нэмэлт үйлчилгээ |
| 6 | Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдаа, засвар, тохируулгын үйлчилгээ |
| 7 | Эрүүл мэндийн удирдлага, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа |
| 8 | Эрүүл мэндийн бусад үйл ажиллагаа |
| 9 | Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаа |
| 10 | Спортын уралдаанд бэлтгэх, оролцох үйл ажиллагаа |
| 11 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 12 | Бусад үйл ажиллагаа |
| | Барилга, хот байгуулалтын сайд |
| 1 | Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ |
| 2 | Ипотекийн үнэт цаасны зах зээлийн бодлого, зохицуулалтын үйл ажиллагаа |
| 3 | Хүн амын ундны усан хангамжийн үйл ажиллагаа |
| 4 | Газрын харилцаа, геодези, зураг зүйн бодлого, зохицуулалтын үйл ажиллагаа |
| 5 | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлтэй холбогдсон харилцааны бодлого, зохицуулалтын үйл ажиллагаа |
| 6 | Хот байгуулалт, нутагшилт, суурьшлын бодлого, зохицуулалтын үйл ажиллагаа |
| 7 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 8 | Бусад үйл ажиллагаа |
| | Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд |
| 1 | Зам, тээвэр, аялал жуулчлал, шуудангийн бодлого, зохицуулалт, хяналтын үйл ажиллагаа |
| 2 | Авто замын сүлжээг өргөтгөн сайжруулах, авто замын дэд бүтцийг хөгжүүлэх үйл ажиллагаа |
| 3 | Тээврийн үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа |
| 4 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагаа |
| 5 | Шуудангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа |

| | |
|---|---|
| 6 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 7 | Бусад үйл ажиллагаа |
| | **Түлш, эрчим хүчний сайд** |
| 1 | Түлш, эрчим хүчний бодлого, зохицуулалт, хяналтын үйл ажиллагаа |
| 2 | Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаа |
| 3 | Сэргээгдэх эрчим хүч, шингэрүүлсэн шатдаг хий, нүүрсний гүн боловсруулалтын үйл ажиллагаа |
| 4 | Эрчим хүчний хөгжил, стратегийн судалгаа, мэдээллийн үйл ажиллагаа |
| 5 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 6 | Бусад үйл ажиллагаа |
| | **Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд** |
| 1 | Мэргэжлийн хяналт шалгалтын үйл ажиллагаа |
| 2 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 3 | Мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа |
| 4 | Бусад үйл ажиллагаа |
| | **Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд** |
| 1 | Гамшгаас урьдчилан сэргийлэх,хамгаалах тусламж, үйлчилгээ |
| 2 | Гамшгаас аврах, эрэн хайх, тандан тодорхойлох тусламж, үйлчилгээ |
| 3 | Гал түймэр унтраах тусламж, үйлчилгээ |
| 4 | Гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох ажил, үйлчилгээ |
| 5 | Улсын нөөцийн барааны бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагаа |
| 6 | Бусад үйл ажиллагаа |
| | **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга** |
| 1 | Үндсэн хуулийн талаархи маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа |
| 2 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 3 | Бусад үйл ажиллагаа |
| | **Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч** |
| 1 | Шүүн таслах үйл ажиллагаа |
| 2 | Бусад үйл ажиллагаа |
| | **Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга** |
| 1 | Шүүн таслах үйл ажиллагаа |
| 2 | Шүүхийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах нийтлэг үйлчилгээ |
| 3 | Бусад үйл ажиллагаа |
| | **Улсын ерөнхий прокурор** |
| 1 | Прокурорын үндсэн үйл ажиллагаа |
| 2 | Прокурорын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах нийтлэг үйлчилгээ |
| 3 | Бусад үйл ажиллагаа |
| | **Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга** |
| 1 | Үндэсний аюулгүй байдлыг хангах, сахих үйл ажиллагаа |
| 2 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 3 | Бусад үйл ажиллагаа |
| | **Монгол Улсын ерөнхий аудитор** |
| 1 | Гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаа |
| 2 | Санхүүгийн тайлангийн аудитын үйл ажиллагаа |
| 3 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 4 | Бусад үйл ажиллагаа |

| | |
|---|---|
| | Үндэсний статистикийн газрын дарга |
| 1 | Улсын албан ёсны мэдээлэл гаргах үйл ажиллагаа |
| 2 | Улсын хэмжээний тооллого, судалгаа явуулах үйл ажиллагаа |
| 3 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 4 | Бусад үйл ажиллагаа |
| | Санхүүгийн зохицуулах хорооны дарга |
| 1 | Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа |
| 2 | Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах үйлчилгээ |
| 3 | Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааг зохицуулах үйлчилгээ |
| 4 | Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулах үйлчилгээ |
| 5 | Даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах үйлчилгээ |
| 6 | Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа |
| 7 | Санхүүгийн зах зээлийн талаархи мэдээлэл, сурталчилгаа, сургалтын үйл ажиллагаа |
| 8 | Бусад үйл ажиллагаа |
| | Төрийн албаны зөвлөлийн дарга |
| 1 | Төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдлагаар хангах үйл ажиллагаа |
| 2 | Төрийн байгууллагыг өөрчлөн хөгжүүлж, бизнесийн чадавхийг сайжруулах үйл ажиллагаа |
| 3 | Төрийн албан хаагчийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа |
| 4 | Төрийн байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг сайжруулах үйлчилгээ |
| 5 | Төрийн албаны удирдах ажилтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагаа |
| 6 | Төрийн албаны мэдээллийн технологийг хөгжүүлэх үйл ажиллагаа |
| 7 | Бусад үйл ажиллагаа |
| | Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга |
| 1 | Бодлогын зөвлөгөө өгөх үйл ажиллагаа |
| 2 | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн нэр төрийг сэргээх, сурталчлах, хэлмэгдүүлэлтийн шалтгаан, нөхцөлийг судлах үйл ажиллагаа |
| 3 | Бусад үйл ажиллагаа |
| | Сонгуулийн ерөнхий хорооны дарга |
| 1 | Сонгуулийн эрх зүйн асуудлаар бодлогын зөвлөгөө өгөх |
| 2 | Сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаа |
| 3 | Сонгуулийн хууль, тогтоомжийн биелэлтийг хянан шалгах |
| 4 | Сонгуулийн мэдээллийн үйлчилгээ |
| 5 | Бусад үйл ажиллагаа |
| | Хүний эрхийн үндэсний комиссын дарга |
| 1 | Хүний эрхийн боловсрол, сурталчилгааны үйл ажиллагаа |
| 2 | Хүний эрхийн хамгаалалтын талаархи мэдээлэл, судалгаа, хяналтын үйл ажиллагаа |
| 3 | Бусад үйл ажиллагаа |
| | Орон нутгийн засаг захиргааны үйлчилгээ |
| 1 | Иргэдэд үзүүлэх засаг захиргаа, иргэний бүртгэлийн болон бусад үйлчилгээ |
| 2 | Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа |
| 3 | Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа |
| 4 | Орон нутгийн засаг захиргааны хяналт шинжилгээний үйл ажиллагаа |
| 5 | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаа |
| 6 | Сонгууль, бүх нийтийн санал асуулгын үйл ажиллагаа |
| 7 | Орон нутгийн хяналт шалгалт, аудитын үйл ажиллагаа |
| 8 | Бусад үйл ажиллагаа |

***Засгийн газрын 2006 оны 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт***

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН АНГИЛАЛ**

А. Улсын төсөв

| | |
|---|---|
| 1 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга |
| 2 | Монгол Улсын Их Хурлын дарга |
| 3 | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга |
| 4 | Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч |
| 5 | Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга (Орон нутгийн шүүх) |
| 6 | Улсын ерөнхий прокурор |
| 7 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга |
| 8 | Монгол Улсын Ерөнхий сайд |
| 9 | Монгол Улсын Шадар сайд |
| 10 | Байгаль орчны сайд |
| 11 | Барилга, хот байгуулалтын сайд |
| 12 | Батлан хамгаалахын сайд |
| 13 | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| 14 | Гадаад хэргийн сайд |
| 15 | Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд |
| 16 | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд |
| 17 | Сангийн сайд |
| 18 | Түлш, эрчим хүчний сайд |
| 19 | Үйлдвэр, худалдааны сайд |
| 20 | Хууль зүй, дотоод хэргийн сайд |
| 21 | Хүнс, хөдөө аж ахуйн сайд |
| 22 | Эрүүл мэндийн сайд |
| 23 | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дарга |
| 24 | Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд |
| 25 | Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд |
| 26 | Төрийн албаны зөвлөлийн дарга |
| 27 | Сонгуулийн ерөнхий хорооны дарга |
| 28 | Хүний эрхийн Үндэсний комиссын дарга |
| 29 | Монгол Улсын ерөнхий аудитор |
| 30 | Санхүүгийн зохицуулах хорооны дарга |
| 31 | Үндэсний статистикийн газрын дарга |
| 32 | Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга |

Б. Орон нутгийн төсөв

| | |
|---|---|
| 1 | Архангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 2 | Архангай аймгийн Засаг дарга |
| 3 | Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 4 | Баянхонгор аймгийн Засаг дарга |
| 5 | Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 6 | Баян-Өлгий аймгийн Засаг дарга |
| 7 | Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 8 | Булган аймгийн Засаг дарга |
| 9 | Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 10 | Говь-Алтай аймгийн Засаг дарга |
| 11 | Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 12 | Говьсүмбэр аймгийн Засаг дарга |
| 13 | Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 14 | Дорноговь аймгийн Засаг дарга |
| 15 | Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 16 | Дундговь аймгийн Засаг дарга |
| 17 | Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 18 | Дорнод аймгийн Засаг дарга |
| 19 | Завхан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 20 | Завхан аймгийн Засаг дарга |
| 21 | Өвөрхангай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 22 | Өвөрхангай аймгийн Засаг дарга |
| 23 | Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |

| | |
|---|---|
| 24 | Өмнөговь аймгийн Засаг дарга |
| 25 | Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 26 | Сэлэнгэ аймгийн Засаг дарга |
| 27 | Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 28 | Сүхбаатар аймгийн Засаг дарга |
| 29 | Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 30 | Төв аймгийн Засаг дарга |
| 31 | Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 32 | Увс аймгийн Засаг дарга |
| 33 | Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 34 | Ховд аймгийн Засаг дарга |
| 35 | Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 36 | Хөвсгөл аймгийн Засаг дарга |
| 37 | Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 38 | Хэнтий аймгийн Засаг дарга |
| 39 | Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 40 | Дархан-Уул аймгийн Засаг дарга |
| 41 | Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 42 | Нийслэлийн Засаг дарга |
| 43 | Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга |
| 44 | Орхон аймгийн Засаг дарга |
| 45 | Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нар |
| 46 | Сум, дүүргийн Засаг дарга нар |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 3 дугаар сарын 1-ний өдөр** **Дугаар 25** **Улаанбаатар хот**

**Хэлэлцээр батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2005 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг батлахсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**ГАДААД ХЭРГИЙН САЙД Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 3 дугаар сарын 1-ний өдөр** **Дугаар 26** **Улаанбаатар хот**

**Протокол батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2005 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан 1984 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулсан "БНМАУ-ын Цагаандаваны гянт болдын орд газрыг эзэмшихэд хамтран ажиллах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг цуцлах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хоорондын протокол"-ыг батлахсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**ГАДААД ХЭРГИЙН САЙД Н.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2005 оны 7 дугаар сарын 05–ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот

### Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 17.11 дэх заалтыг нэг мөр ойлгох явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 17.11-дэх заалтын "төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж болно" гэсэн ажиллагаа 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн хийгдэх боловч энэхүү жагсаалтанд бүртгэгдэх хүмүүст тавигдах шаардлага буюу "төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаал эрхэлж байсан төрийн албан хаагч" гэдэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ноос өмнө тухайн албан тушаалыг эрхэлж байсан хүмүүсийг нэгэн адил хамааруулан ойлговол зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч.ГАНБАТ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН Ц.АМАРСАЙХАН

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 26–ны өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

### Арбитрын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Арбитрын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн[1] 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн[2] 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Арбитрын тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг дараахь байдлаар тайлбарласугай.

1. Арбитрын тухай Монгол Улсын хууль /цаашид хууль гэх/-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн "Маргаан шийдвэрлэх арбитр нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ажиллагаа явуулах тохиолдолд энэ хууль үйлчилнэ" гэдгийг арбитрын ажиллагаанд оролцож байгаа талууд маргаанаа Монгол Улсын арбитраар шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон, эсхүл арбитрын ажиллагаа явуулах газар Монгол Улсын нутаг дэвсгэр байхаар арбитрын бүрэлдэхүүн тогтоосон тохиолдолд Арбитрын тухай Монгол Улсын хууль үйлчилнэ гэж ойлгож хэрэглэнэ

2. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын "талууд тухайн маргаанаар шүүхэд эхэлж нэхэмжлэл гаргасан боловч нэхэмжлэлийн шаардлагын талаар тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрт шилжүүлэх тухай хүсэлт гаргасан..." гэдгийг иргэний хэрэг үүсгэсэн эсэхээс үл хамааран талууд хамтдаа болон тус тусдаа хүсэлт гаргасныг ойлгох бөгөөд шүүхэд нэхэмжлэлийн шаардлагын талаар хариу тайлбар гаргаснаас хойш маргааныг арбитраар шийдвэрлүүлэх хүсэлт гаргах эрхгүй гэж ойлговол зохино.

3. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасанаар "шүүх, талуудын хооронд хийсэн арбитрын хэлэлцээр хүчинтэй" гэж үзэх үндэслэл нь талууд хоорондоо арбитрын хэлэлцээрийг бичгийн хэлбэрээр байгуулсан , талуудын өөрийн буюу төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан он, сар, өдөр нь тодорхой баримт үйлдсэн байхыг;

Мөн зүйлийн талуудын хооронд хийсэн арбитрын хэлэлцээр "хэрэгжих боломжтой" гэдгийг уг хэлэлцээр нь хөөн хэлэлцэх хугацаа, маргааны харъяаллын хувьд арбитр шийдвэрлэхэд харшлах зүйлгүй байхыг ойлгоно.

Талуудын хооронд хийсэн арбитрын хэлэлцээр хүчинтэй бөгөөд хэрэгжих боломжтой гэж үзвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд[3] заасан журмын дагуу шүүгч захирамж, шүүх тогтоол гарган хүсэлтийг шийдвэрлэнэ

4. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "Арбитрын бүрэлдэхүүн нэг буюу хэд хэдэн арбитрчаас бүрдэж болно" гэсэн заалтыг тухайн арбитрын ажиллагаанд оролцох арбитрчийг талуудын дунд нэг арбитрч, эсхүл нэгээс дээш хэдэн ч арбитрч байж болно гэж ойлгоно.

[1] Монгол Улсын Үндсэн хууль. – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугээрт нийтлэгдсэн

[2] Шүүхийн тухай хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 29 дүгээрт нийтлэгдсэн.

[3] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

5. Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан "тухайн маргаанаар арбитрын ажиллагаа явуулах арбитрчийн тоог талууд харилцан тохиролцоно" гэдгийг тухайн маргааныг нэг арбитрч шийдвэрлэхээр тохиролцоогүй бол талууд тус тусдаа адил тооны арбитрчийг томилохоор тохиролцохыг хэлнэ.

6. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.8, 40 дүгээр зүйлийн 40.5-д заасан шүүхийн "шийдвэр" гэдгийг Шүүхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасны дагуу "давж заалдах шатны шүүхээс тогтоол гаргана гэж ойлгож хэрэглэнэ.

Давж заалдах шатны шүүхийн дээрх тогтоолд гомдол гаргах журмыг хуулиар тогтоогдоогүй тул уг тогтоол эцсийн шийдвэр байна.

7. Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дах заалтын "эргэлзээ төрүүлэхүйц нөхцөл байдал" гэдэгт урьд талуудын маргаантай асуудлыг шүүх, арбитрт хянан шийдвэрлэхэд зохигч, гуравдагч этгээд, иргэдийн төлөөлөгч, өмгөөлөгч, гэрч, шинжээч, орчуулагчаар оролцож байсан хэргийн талуудтай төрөл садан, хувийн харилцаатай, тухайн арбитрын бүрэлдэхүүнд оролцож байгаа арбитрчтай төрөл садан, хэрэгт оролцож байгаа талууд, тэдгээрийн төлөөлөгчтэй албан ажлын хувьд захирах захирагдах харилцаанд байдаг зэрэг уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах талаар үндэслэл бүхий эргэлзээтэй байдлыг хамааруулан ойлгоно.

8. Хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т заасан "горимын шинжтэй асуудал" гэдэгт арбитрын шийдвэр гаргах, шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах, тайлбарлах, нэмэлт шийдвэр гаргах, арбитрын ажиллагааны журмыг тодорхойлох, арбитрчийг татгалзан гаргах, нөхөн томилохоос бусад арбитрын ажиллагааны явцад гарах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудлыг ойлгоно.

9. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан "арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай хүсэлтийг арбитрын ажиллагаа явагдсан газрын давж заалдах шатны шүүхэд гаргаж болно" гэдгийг шийдвэр гаргасан арбитрын оршин байгаа газрын давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргахыг хэлнэ.

10. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2 дахь хэсгийн "...нэхэмжлэлийн шаардлага, татгалзал, мэдүүлэг, холбогдох бусад нотлох баримтын талаар тайлбар хийх боломжоор тэднийг хангаагүй" гэснийг нэхэмжлэлийн өргөдөл, татгалзал, маргаанд холбогдох баримт бичиг, бусад мэдээлэл болон арбитрын шийдвэрийн үндэслэл болж буй мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, нотолгооны шинжтэй бусад баримт бичигтэй танилцах боломжтой цаг хугацааны өмнө талуудад хүргүүлээгүй, түүнээс гадна арбитрын бүрэлдэхүүн нь нотлох баримтыг тайлбарлах, мэтгэлцэх боломж талуудад олгоогүй байхыг ойлгоно.

11. Хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-д заасан "...шүүх арбитрын шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл тухайн арбитрын шийдвэрийг баталгаажуулж ... гүйцэтгэх хуудас бичнэ" гэдгийг арбитрын шийдвэрийг хүчингүй болгох тухай гомдол шүүхэд гараагүй, энэ үндэслэлээр гомдол гаргах хугацаа дууссан тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд тавигдсан шаардлагыг хангаж чадахуйц бүрдэл бүхий сонирхогч талын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн шүүгч арбитрын шийдвэрийг баталгаажуулах тухай захирамж гаргаж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.3-т заасны дагуу гүйцэтгэх хуудас бичнэ гэж ойлгож хэрэглэнэ.

12. Хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т "Давж заалдах шатны шүүх ... арбитрын шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй" гэж заасны дагуу хуульд заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн арбитрын бүрэлдэхүүн талуудын хүсэлтээр хуульд заасны дагуу арбитрын ажиллагаа явуулж, хэргийг ердийн журмаар шийдвэрлэнэ.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР**

**ШҮҮГЧ А.ДОРЖГОТОВ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

**2005 оны 12 дугаар сарын 26–ны өдөр** | **Дугаар 46** | **Улаанбаатар хот**

### УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГСДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. дэх заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ нь:**

1.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. дэх хэсгийн "... хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд нэг сая төгрөгийн, ... нэг

удаагийн нөхөх олговор олгоно" гэсэн заалтын "хэлмэгдэгч" гэдэгт энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1., 5.1.2., 5.1.3.-т заасан бүх хэлмэгдэгчийг хамааруулах бөгөөд тэдгээр нь нас барсан бол гэр бүлийн гишүүд нь 1 сая төгрөгийн нэг удаагийн нөхөх олговор авах эрхтэй гэж ойлговол зохино.

2.Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. дэх хэсгийн "...бусад хэлмэгдэгчид 500000 төгрөгийн нэг удаагийн нөхөх олговор олгоно" гэдгийн " бусад хэлмэгдэгч" гэдэгт энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2., 5.1.3.-т заасан хэлмэгдэгч нь өөрөө амьд сэрүүн байгаа бол 500000 төгрөгийн нэг удаагийн нөхөх олговор авах эрхтэй гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР

ТАНХИМЫН ТЭРГҮҮН Ц.АМАРСАЙХАН

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

**2006 оны 2 дугаар сарын 20–ны өдөр** **Дугаар 01** **Улаанбаатар хот**

### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 49 ДҮГЭЭР ЗҮЙЛ /ЭД ХӨРӨНГӨ ХУРААХ/-ИЙГ НЭГ МӨР ОЙЛГОЖ, ЗӨВ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Эд хөрөнгө хураах ялын тухай Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5 дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйл /Эд хөрөнгө хураах/-ийг дараах байдлаар тайлбарласугай. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн " ... хувьд ногдох эд хөрөнгө ... " нь Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.3 дахь хэсэгт дурьдсан тухайн этгээдийн өөрт нь өмчлөгдсөн иргэний эд хөрөнгө, дундын өмчлөлийн эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс бүрдэнэ. Дундаа хэсгээр өмчлөгчийн түүнд ногдох хэсгийг Иргэний хуулийн 108, 129 дүгээр зүйлд зааснаар тус тус тодорхойлж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.7-д заасан үндэслэлийг баримтлаж гаргуулна.

2. Мөн зүйл, хэсгийн " ... хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулах ... " гэснийг Эрүүгийн хуулийн тусгай ангид гэм буруутай этгээдийн эд хөрөнгийг хураахаар заасан байвал түүнд ногдох бүх эд хөрөнгийг, зарим хэсгийг хураахаар заасан байвал түүнд ногдох эд хөрөнгийн тодорхой хэсгийг буюу тодорхой эд зүйл, эсхүл түүний үнийг хариу төлбөргүйгээр өмчлөгч этгээдийн хүсэл зоригоос үл хамааран шүүхийн шийтгэх тогтоолд заасан хэмжээгээр хураан авч, төрийн өмчлөлд шилжүүлнэ гэж ойлгоно.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим зүйл, хэсэгт заасан "эд хөрөнгийг хурааж" гэдгийг гэм буруутай этгээдийн хувьд ногдох бүх эд хөрөнгийг шүүх заавал албадан гаргуулна гэж ойлгоно.Харин "эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр" гэснийг гэм буруутай этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг хураах ял хэрэглэх эсэх нь шүүхийн эрх хэмжээний асуудал гэж ойлговол зохино.

Эд хөрөнгийн заримыг хураахдаа тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн арга, орон цаг, гэм буруутай этгээдийн хувийн болон гэр бүл, эд хөрөнгийн байдлыг харгалзан хураах эд хөрөнгийн нэр төрөл, хэмжээ, түүний үнийг тогтооно.

4. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгө мөн боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйл /Төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө/-д заасан зайлшгүй хэрэгцээт хоол хүнс, гал тогооны хэрэгсэл, төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас, хүйтний улиралд хэрэглэх түлээ түлш, мал аж ахуй болон газар тариалан эрхэлдэг бол амьжиргааны наад захын хэрэгцээг хангах тооны мал, тариалах үр, төлбөр төлөгч-иргэн мэргэжлийнхээ ажил, үйлдвэрлэл явуулахад зайлшгүй шаардагдах эд юмсыг хураан авахаар шүүх шийдвэрлэж болохгүй.

5. Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийн "Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ" гэдэгт гэм буруутай этгээд нь Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэрэг үйлдэх явцдаа хууль бусаар олж авсан эд юмс, тэдгээрийн зах зээлийн үнэлгээг ойлгоно.

Харин зах зээлийн үнэлгээнээс өндөр үнээр худалдан борлуулсан бол үнэлгээг худалдан борлуулсан үнээр тооцно.

6. Мөн зүйл, хэсгийн гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн " ... зэвсэг ... " гэдэгт Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай Монгол Улсын Дээд шүүхийн 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан иж бүрдэл, бүтцийн хувьд амьд болон бусад биетийг устгах,

гэмтээх, мөн бие хамгаалах болон дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулна.

Зэвсэг нь галт, хүйтэн болон хийн, мөн үйлдвэрийн эсхүл гар хийцийн аль нь ч байж болно гэж ойлгоно.

7. Мөн зүйл, хэсгийн гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн "тээврийн болон бусад хэрэгсэл" гэдэгт гэм буруутай этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхдээ учруулж болох хор аюулын хэмжээг ихэсгэх, гэмт үйлдлээ түргэсгэх, олж авсан эд зүйлийг зөөж тээвэрлэх, гэмт хэргийн газраас зугтах зорилгоор хэрэглэсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүх төрлийн тээврийн хэрэгсэл, гэмт үйлдлээ хялбар болгох, хохирогчийн эсэргүүцлийг няцаах, учирч болох саадыг арилгахын тулд ашигласан төрөл бүрийн тэсрэх дэлбэрэх болон түргэн шатамхай буюу түргэн хордуулах бодисууд, хориотой үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, барилга байгууламж зэргийг хамааруулна.

8. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн болон бусад хэрэгслийг тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэхээр заасан эсэхийг үл харгалзан эд хөрөнгө хураах ялаас гадуур Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийг журамлан заавал хураана.

9. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, техник болон бусад хэрэгсэл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг үнэ, төлбөргүйгээр улсын орлого болгох буюу уг зэвсэг, хэрэгслийн онцлогийг харгалзан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нийцүүлэн устгана.

Харин хадгалалт, тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардагддаг, хадгалах хугацаа богино, амархан муудаж чанараа алддаг болон гэмтэх зүйлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт зааснаар нэн даруй борлуулж, үнийг улсын орлого болгох буюу зохих эзэнд нь олгоно.

Мөнгөн ус, нитроглицерин, нитрогликоль, пироксилин, тротил, дарь, динамит, оксиликвит, азотын хүчилтэй нитробензолын уусмал, нүүрс, ус төрөгчийн нийлбэр, хийтэй металл зэрэг эгшин зуурт өөрөө тархах буюу химийн урвалд ордог тэсрэх дэлбэрэх бодисууд, зайлшгүй шаардлагатай үед эмч, мэргэжилтний хатуу хяналттай хэрэглэдэг бөгөөд өчүүхэн төдий тун хэтэрвэл амьд организм, ургамал, газар шороог үхүүлэх буюу хордуулах үйлчилгээтэй хорт бодисуудыг түүний онцлогийг харгалзан устгах, зохих байгууллагад шилжүүлж устгуулах, эсхүл хэрэглээнийх нь дагуу холбогдох байгууллагад нь шилжүүлж байвал зохино.

Гэм буруутай этгээд нь бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд байсан эд хөрөнгийг гэмт хэрэг үйлдэх явцдаа олж авсан, зэвсэг, тээврийн болон бусад хэрэгслийг хууль бусаар өөрийн эзэмшилд шилжүүлэн авч, улмаар гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан нь тогтоогдсон бол тэдгээрийг хурааж, жинхэнэ өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид нь шүүхийн шийтгэх тогтоолоор олгож байвал зохино. Мөн гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг зөөж, тээвэрлэж буйгаа мэдээгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн тээврийн хэрэгслийг хурааж болохгүй.

10. Тээврийн хэрэгслийн жолооч нь тээврийн хэрэгслээ гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, эсхүл ашиглуулсан болохоо мэдсэн эсэхийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын шатанд заавал тогтоосон байвал зохино.

11. Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийг, мөн хуулийн тусгай ангийн зохих зүйл хэсэгтэй, харин гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн болон бусад хэрэгслийг хураахдаа зөвхөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсгийг тус тус баримтлана.

12. Хэрэв Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэгт эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг хэрэглэхээр заасан бол гэмт хэрэг үйлдсэн этгээдийн энэ тайлбарын 1 дэх хэсэгт заасан өмчлөлийн эд хөрөнгийн нэр төрөл, хэмжээ, үнэлгээг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын шатанд нэг бүрчлэн тогтоож, төрийн өмчид хураан авах боломжийг хангах арга хэмжээ авна.

13. Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулахдаа хураах эд хөрөнгийн нэр төрөл, хэлбэр, тоо хэмжээ, түүний үнэлгээг мөнгөн илэрхийлэлд оруулж шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заасан байна.

14. Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний зах зээлийн хийгээд борлуулсан үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн болон бусад хэрэгслийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын шатанд нэг бүрчлэн тогтоож, зохих журмын дагуу битүүмжилсэн, эсхүл хураан авсан байвал зохино.

15. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 1994 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР**

**ШҮҮГЧ С.НЯМЖАВ**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

**2006 оны 2 дугаар сарын 20–ны өдөр** **Дугаар 02** **Улаанбаатар хот**

### Улсын Дээд шүүхийн 2003 оны 23 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Улсын Дээд шүүхийн 2003 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 23 дугаар тогтоолын 9 дүгээр заалтын "Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7 дахь заалтаас гадна мөн хуулийн 147 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилж, нийлмэл гэмт хэрэг гэж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой" гэсэн хэсэг нь Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7 дахь хэсэгтэй зөрчилдөж байгааг үндэслэн Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Дээрмийн гэмт хэргийг үйлдэх явцдаа хүнийг санаатай алсан бол Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7 дахь хэсгээр зүйлчилж эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд дээрмийн гэмт хэргээр давхар зүйлчлэхгүй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Дээд шүүхийн 2003 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 23 дугаар тогтоолын 9 дүгээр заалтын "Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7 дахь заалтаас гадна мөн хуулийн 147 дугаар зүйлийн аль тохирох хэсгээр давхар зүйлчилж, нийлмэл гэмт хэрэг гэж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой" гэсэн хэсгийг хүчингүй болгосугай.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН Д.БАТСАЙХАН**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

**2006 оны 2 дугаар сарын 20–ны өдөр** **Дугаар 03** **Улаанбаатар хот**

### Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай

Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгийн "зэвсэг", "зэвсгийн чанартай бусад зүйл" гэсэн заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсэгт заасан "*зэвсэг*" гэдэгт иж бүрдэл, бүтцийн хувьд амьд болон бусад биетийг устгах, гэмтээх, мөн бие хамгаалах болон дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно.

Зэвсэг нь галт, хүйтэн болон хийн, мөн үйлдвэрийн эсхүл гар хийцийн аль нь ч байж болно.

2. "*Зэвсгийн чанартай бусад зүйл*" гэдэгт ахуйн болон аж ахуйн зориулалт бүхий /тухайлбал, хайч, сэрээ, сүх, хөрөө, халив (отвёртка), хүрз, өрөм, лоом, гал тогооны болон сахлын хутга г.м./ эсхүл хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулж болох /тухайлбал, бороохой, ташуур, мод, төмөр, чулуу, шил, зодооны хэрэгсэл, бүх төрлийн химийн шингэн ба хатуу бодис г.м./ эд зүйл, хэрэгслийг ойлгоно.

Зэвсгийн чанартай бусад зүйлийг тусгайлан бэлтгэсэн буюу засаж тохируулсан эсэх нь хэргийг Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3-т зааснаар зүйлчлэхэд нөлөөлөхгүй.

3. Зэвсэг, зэвсгийн чанартай бусад зүйлийг танхайрах явцдаа хэрэглэсний улмаас хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учирсан эсэхээс үл хамааран хэргийг Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3-т зааснаар зүйлчилнэ.

4. Танхайрах явцдаа хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулах, түүнчлэн танхайн үйлдэлдээ хүч оруулах, айлган сүрдүүлэхэд чиглэсэн шууд санаагаа өөрийн хүсэл зоригоос үл хамааран туйлд нь хүргэж чадаагүй бол тухайн этгээдэд гэмт хэрэг үйлдэхээр завдсанаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ С.БАТДЭЛГЭР**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН Д.БАТСАЙХАН**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 3.5

☎ 329487